



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЫН ЯАМ



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ



ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ ШААРДЛАГАТАЙ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНД,
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

ЭХ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ



ТУСАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ ШААРДЛАГАТАЙ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНД,
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

ЭХ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

2019 он

ННА 74.3
ДАА 371.9
Э-94

ТӨСЛИЙН ЗОРИЛТОТ АЙМАГ, ДҮҮРГИЙН ХӨТӨЛБӨРТ
ХАМРАГДСАН БАЙГУУЛЛАГУУД:

- Баянгол дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс
- Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв (Ахмад настан, хүүхдийн эмнэлэг)
- Баянгол дүүргийн 8 дугаар хороо
- Нийслэлийн 186 дугаар тусгай цэцэрлэг
- Сувилалын цэцэрлэг яслийн 10 дугаар цогцолбор
- Хөвсгөл аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс
- Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газар
- Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэг
- Мөрөн сумын 4 дүгээр цэцэрлэг
- Мөрөн сумын 10 дугаар цэцэрлэг
- Тариалан сумын Эрүүл мэндийн төв
- Рэнчинлхүмбэ сумын цэцэрлэг

Энэхүү ном нь Монгол Улсын “Зохиогчийн эрхийн тухай” хуулиар баталгаажсан тул эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр хэсэгчлэн болон бүтнээр нь дахин хэвлэх, цахим болон бусад хэлбэрээр хувиран олшруулах, түгээн тараахыг хориглоно.

Цаасны хэмжээ: В5
Хэвлэлийн хуудас: 4.0 х.х

“Мөнхийн Үсэг” ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

ISBN: 978-9919-9519-3-1

ГАРЧИГ

Удиртгал.....	4
Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийн талаарх сэтгэгдлүүд.....	5
НЭГ. Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийн тухай үндсэн ойлголт.....	7
1.1 Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр гэж юу вэ?.....	7
1.2 Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийн үндсэн зарчим.....	8
1.3 Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр дэх дэмжлэг.....	8
1.4 Зохион байгуулах аргачлал.....	9
ХОЁР. Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийг зохион байгуулах үйл явц.....	13
2.1 Бэлтгэл хангах.....	13
2.2 Тухайн өдрийн хөтөлбөр.....	17
2.3 Үндсэн хөтөлбөрийг зохион байгуулах.....	18
2.4 Багш нарын чиг үүрэг.....	25
2.5 Анхаарах зүйл.....	26
Хавсралт 1 Харилцах дэвтэр.....	27
Хавсралт 2 Хүүхдийн мэдээлэл болон сар бүрийн тэмдэглэл (Маягт, жишээ).....	37

УДИРТГАЛ

Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA) хамтран 2015 оны 8 дугаар сараас “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлж байна. Энэхүү төслийн эрхэм зорилго нь хүүхэд бүр хэрэгцээндээ нийцсэн хөгжлийн дэмжлэг ба боловсролын үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлж, хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх, чанартай боловсрол олгох тогтолцооны загварыг боловсруулахад чиглэсэн.

Төслийн хүрээнд хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлж, шаардлагатай дэмжлэгийн үйлчилгээнд хамруулах зорилгоор Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн ашиглалтын чанарыг сайжруулах, 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг зохион байгуулах явцад тухайн насанд байвал зохих хөгжлийн үзүүлэлтүүд нь хоцорсон хүүхдүүдийн хөгжлийг дэмжих, тэднийг зөвхөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд илгээгээд зогсохгүй, эцэг эхэд нь зөвлөгөө өгөх болон цэцэрлэгт хамруулахад нь холбон зуучилж дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байлаа. Эрт үеийн хөгжлийн дэмжлэг нь хоёрдогч бэрхшээлээс урьдчилан сэргийлэх болон хүүхдийн хөгжлийг боломжит дээд хэмжээнд хүргэхэд туйлын чухал гэж үздэг.

Япон Улсад эрүүл мэнд, хөгжлийн үзлэгээр хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй нь илэрсэн хүүхдийн хөгжлийг дэмжих, чадварыг сайжруулах зорилгоор тэдгээр хүүхдүүдийг хамтад нь тоглуулангаа эх эцгийг нь байлцуулан хүүхдээ хэрхэн хөгжүүлэх талаар зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлдэг “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-ийг зохион байгуулдаг байна.

Төслийн сонгосон аймаг, дүүрэгт 1.5 жилийн хугацаанд Японы туршлагаас судлан “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсэн туршлагад үндэслэн энэхүү гарын авлагыг боловсруулав.

Гарын авлагад “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр” (Цаашид ЭХХХ гэх)-ийн талаарх үндсэн ойлголт болон тогтвортой хэрэгжүүлэх, үр өгөөжтэй зохион байгуулах арга зүй зэргийг тусгасан болно.

Та бүхэн энэхүү гарын авлагыг ашиглан “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-ийг өргөжүүлэн үндэсний хэмжээнд хэрэгжүүлж, хүүхдийн хөгжлийг дэмжих, хоцрогдол бэрхшээлтэй хүүхдийг бусдын адил өсч хөгжих боломжийг бүрдүүлж ажиллана гэдэгт найдаж байна.

ЭХ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ТАЛААРХ СЭТГЭГДЛҮҮД

186 дугаар тусгай цэцэрлэгийн эрхлэгч Д.ЭНХМӨНХ (ЭХХХ-ийн зөвлөх):

Энэхүү хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлсэн, нутагишуулсан, цаашид тогтвортой хэрэгжих боломжийг бүрдүүлсэн ЖАЙКА, БСШУСЯ, ХНХЯ болон гар бие оролцсон бүх хүмүүст талархал илэрхийлье.

Хүүхэд бүрийн тодорхой насанд харагддаг өсөлт, хөгжлийг танин мэдэхүй, бие бялдар, нийгэмшлэхүй, сэтгэлийн хөдөлгөөний хувьд харж болох, хөгжлийн хоцрогдлыг нь эрт илрүүлэх, тохирох тусламж үйлчилгээг үзүүлэхэд ЭХХХ-ийн гол утга нь оршиж байна гэж боддог.

Энэхүү ном “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-ийг эхлүүлэх, хүүхдийг хөгжүүлэх, орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлан хэрхэн дэмжиж хэрэгжүүлэх боломжтой талаар мэдлэг, мэдээлэл өгнө гэдэгт итгэлтэй байна.

Сайн үйл бүхэн дэлгэрэх болтугай.

БГД-ийн Салбар комиссын гишүүн Э.НЯМАА, Б.ЦЭЦҮҮДЭЙ, БГДЭМТ-ийн хөдөлгөөн засалч А.Одонтунгалаг (ЭХХХ-ийн багш нар):

Монгол Улсад хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхиээлийг аль болох эрт илрүүлэх, хөгжүүлэхтэй холбоотой асран хамгаалагчдын ойлголт, хандлага сул байгаа явдал нь хүүхдийнхээ хөгжлийн хоцрогдол, бэрхиээлийг үл зөвшөөрөх, хөгжих боломжийг хязгаарлах, улмаар хөгжлийн хоёрдогч бэрхиээл үүсэх зэрэг сөрөг үр дагавруудыг бий болгож байна. “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Баянгол дүүрэгт анх туршин хэрэгжүүлсэн ЭХХХ нь дээрх асуудлуудыг шийдвэрлэх нэг арга зам юм.

ЭХХХ-т эцэг эх, асран хамгаалагчид хүүхэдтэйгээ хамт оролцож, хүүхдийн бие бялдар, сэтгэхүйн хөгжлийг дэмжих тоглоомуудыг хамт тоглох явцдаа хүүхдийнхээ хөгжлийн хоцрогдлыг ойлгож мэдэн, гэртээ хийх боломжтой, хүүхдийнхээ онцлогт тохирсон, хөгжүүлэх энгийн аргуудыг сурдаг. Мөн багш нараас зөвлөгөө авч, бусад эцэг эхчүүдтэй санал бодлоо солилцон хоорондоо нөхөрлөх нь хүүхдээ өсгөж хөгжүүлэхэд гардаг асуудлыг шийдэх, сэтгэл зүйн хямралыг даван туулахад нь дэм болдог.

ЭХХХ нь эцэг эх, асран хамгаалагчдад цаашид өөрсдөө хүүхдээ хөгжүүлж, хөгжлийн хоцрогдлыг багасгахад чиглэсэн аргад суралцах, багш нараас эрүүл мэнд боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээний талаар мэдээлэл, зөвлөгөө авах, шаардлагатай тохиолдолд эдгээр үйлчилгээнд холбон зуучлахад дэмжлэг үзүүлдэг нэн чухал хөтөлбөр юм. Цаашид хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхиээлийг эрт илрүүлэн, аль болох олон хүүхэд, эцэг эхчүүдэд дэмжлэг үзүүлэхийн тулд 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн товлот үзлэгийн хямралтыг сайжруулах шаардлагатай байна.

Хөвсгөл аймгийн 1 дүгээр цэцэрлэгийн багш Д.ЦОЛМОН (ЭХХХ-ийн багш):

Хүүхэд бүхэн өөр өөрийн гэсэн ертөнцтэй. Тэрхүү ертөнцийг үргэлж гэрэл гэгээтэй байлгахад бие сэтгэл, оюун билгээ харамгүй зориулж байдаг хун бүрт ЭХХХ-ийн хамт олны өмнөөс, болон хувиасаа энэ хорвоогийн хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Миний бие ЭХХХ-ийн багшаар бэлтгэгдэж, Хөвсгөл аймагт хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй бага насны хүүхэд, тэдний гэр бүлд хөтөлбөрийн үйл ажиллагааг хүргэж байгаадаа сэтгэл хангалуун байдаг.

Энэхүү хөтөлбөр нь бага насны хүүхдийн хөгжилд чухал үүрэг бүхий үйл ажиллагааг тоглоомын аргаар зохион байгуулах замаар бие махбод, сэтгэцийн хөгжлийг нь дэмжиж, гэр бүлийг нь хүүхэдтэйгээ хэрхэн харилцах аргад суралцуулах, түүнчлэн нийгмийн хамгааллын үйлчилгээнд холбон зуучилдагараа давуу талтай.

Бидний үйл ажиллагаанд хамрагдсан хүүхэд бүр хөтөлбөрийн явцад бусад хүүхэд, аав ээж, багштайгаа харилцаж хэл яриа, хөдөлгөөн, эрүүл мэнд болон сэтгэл зүйд нь маш олон эерэг өөрчлөлт гарч байгаа нь багш бидэнд болон олон хүнд урам зориг, эрч хүч өгдөг.

Иймд ЭХХХ-ийг Монгол эх орныхоо өнцөг булан бүрт зохион байгуулж, тусламж дэмжлэг хэрэгтэй олон мянган бяцхан үрсэд аз жаргал, баяр баясал бэлэглэж, өөртөө итгэлтэй, шийдвэр гаргах чадвартай, нийгэмд бие даасан хувь хүн болон төлөвшихөд нь хүн бүр сэтгэл зүрхээ зориулна гэдэгт итгэлтэй байна. Баярлалаа та бүхэнд.

Эрүүл хүүхэд - Эх дэлхийн ирээдүй

Хөтөлбөрт хамрагдсан ЗАРИМ АСРАН ХАМГААЛАГЧДЫН СЭТГЭГДЭЛ:

- *Эмчилгээ биш учраас хүүхдийн маань эрүүл мэндэд ямар нэг өөрчлөлт гараагүй хэдий ч, чиглүүлэгч багш нар удаа бүр эелдгээр зөвлөгөө өгч байсан бөгөөд хүүхдээ цэцэрлэгт явуулж эхэлсэн. (ЭХХХ-т оролцож эхэлсний дараа тусгай цэцэрлэгт орсон)*
- *Байнга гэртээ ганцаархнаа байсан надад ЭХХХ-т оролцсоноор олон хүмүүстэй танилцаж, хүүхэд маань ч шинэ орчинд дасан нийгэмших байдал нь сайжирч байна.*
- *Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөрт оролцож эхэлснээс хойш чиглүүлэгч багш нар болон бусад хүүхдүүдтэй танилцан дасаж, бүх үйл ажиллагаанд ганцаараа оролцдог болсон. Нийгэмших байдал нь сайжирч байна. Гэртээ байхдаа ч гараа хөдөлгөн дуу дуулж, тоглож байгаа.*
- *ЭХХХ-т дасан чөлөөтэй тоглодог болсон. Сонингоор тоглох болон гараа хөдөлгөн дуулж тоглох зэрэг ЭХХХ-т сурсан тоглоомуудаа гэртээ ч тоглохыг хүсдэг.*


1 ЭХ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ТУХАЙ ҮНДСЭН ОЙЛГОЛТ

1.1 ЭХ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР ГЭЖ ЮУ ВЭ?

ЭХХХ нь хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдийн хэвийн өсөлт, хөгжлийг дэмжих үүднээс үе тэнгийн хүүхдүүдтэй хамтад нь тоглуулах, гэр бүл, асран хамгаалагчид нь хүүхдээ өсгөж бойжуулах талаар зөвлөгөө өгөх замаар хүүхдийг хөгжүүлэх зорилготой. Түүнчлэн, ЭХХХ-ийг зохион байгуулах явцад хүүхдийн бодит байдал, амьдралын нөхцөлийг судлан шаардлагатай зарим хүүхдийг цэцэрлэгт хамруулахад нь дэмжлэгийг үзүүлдэг.

ЭХХХ-ийг өрх, сумын эрүүл мэндийн төвд хийгдэх 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн товлолт үзлэгийн дараах дэмжлэгийн хөтөлбөр гэж үзэх боловч бусад шатны эрүүл мэндийн байгууллага болон “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс” (Цаашид Салбар комисс гэх)-оос илгээсэн хүүхдүүдийг хамруулж байна. Дараах бүдүүвчид үзүүлсэн аймаг, дүүргийн түвшинд хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлэх тогтолцооны загварт ЭХХХ-ийн оролцоог тусгасан болно.

Бүдүүвч 1. Хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх тогтолцоон дахь ЭХХХ-ийн оролцоо



ЭХ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ТУХАЙ ҮНДСЭН ОЙЛГОЛТ

1.2 ЭХ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оршин суугаа нутаг орны нийгмийн амьдралд бусдын адил оролцуулах үзэл санаа болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай Монгол Улсын хуулийн 28 дугаар зүйлд “...хөгжлийн хоцрогдолтой хүүхдэд тусгай хөтөлбөрийн дагуу үйлчилгээ үзүүлэхийг төрөөс дэмжинэ” хэмээн заасанчлан бүх хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хамтдаа өсч хөгжих боломжоор хангах хэрэгцээ шаардлага гарч байна. ЭХХХ нь хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхэд оршин суугаа газартаа бусад хүүхдийн адил өсч бойжиход нь дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа юм.

Мөн ЭХХХ нь “Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ICF)¹” дахь хөгжлийн бэрхшээлийн тухай үзэл баримтлалын хүрээнд хүүхдийн үйлдэл, чадвар алдалтыг засаж эмчлэхээс илүүтэй, тухайн хүүхэд болон түүний гэр бүлийн боломж, давуу талыг түлхүү анхаарч, орчинд (гэр бүл, нийгэм) нь нөлөөлөх замаар хүүхдийн өсөлт, хөгжлийг дэмжих зорилготой.

1.3 ЭХ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР ДЭХ ДЭМЖЛЭГ

ЭХХХ нь хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх зорилго бүхий 1) Хүүхдэд үзүүлэх хөгжлийн дэмжлэг, 2) Гэр бүлд үзүүлэх дэмжлэг, 3) Цэцэрлэгт холбон зуучлах дэмжлэгүүдийг багтаасан багц үйл ажиллагаа юм.

1.3.1 Хүүхдэд үзүүлэх хөгжлийн дэмжлэг

ЭХХХ дэх тоглох хөтөлбөрөөр дамжуулан бага насны хүүхдийн хөгжилд чухал ач холбогдолтой үйл ажиллагааг зохион байгуулж, сэтгэл зүй болон бие бялдрын хөгжлийг нь дэмждэг. Мөн ЭХХХ-ийн тоглох үйлдлүүдийг гэрт нь давтан хийлгэж хэвшүүлэхийг гэр бүлийнхэнд нь зааж хэлж, өдөр тутмын амьдралдаа хүүхдээ хөгжүүлэх талаас нь зөвлөдөг.

ЭХХХ-ийг нэг ээлжинд 6 удаа зохион байгуулах бөгөөд удаа бүрт ижил хөтөлбөрөөр явуулна. Ийнхүү удаа бүр ижил хөтөлбөрөөр зохион байгуулснаар тухайн хүүхдийн хөгжлийн ахицыг (өөрчлөлт) багш болон эцэг эх, асран хамгаалагчид нь харж үнэлэх боломжтой болно.

¹ “Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ICF)”-ыг хүний амьдралын үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээлийг ангилах аргачлал болгон ашиглах зорилгоор 2001 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас баталсан.

1.3.2 Гэр бүлд үзүүлэх дэмжлэг

Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэхэд тухайн хүүхдийн гэр бүлд чиглэсэн дэмжлэг үзүүлэх нь их чухал юм. Хүүхдийнхээ хөгжлийн онцлогийг ойлгож, хоцрогдол, бэрхшээлийг нь хөгжлийн үе шатанд нь нийцүүлэн өсгөж хөгжүүлэх чадварыг эзэмшихэд гэр бүлд нь дэмжлэгийг үзүүлэх нь хүүхдийн хөгжилд эерэг нөлөө үзүүлдэг. ЭХХХ-ийн явцад гэр бүлд дараах дэмжлэгийг үзүүлдэг. Үүнд,

- Хүүхэд өсгөхөд сэтгэл санааг нь зовоож буй асуудлыг хөнгөрүүлэхэд туслах;
- Хүүхдийнхээ талаар ойлгох, идэвхтэй харилцах, өсгөж хөгжүүлэх чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн дэмжлэг үзүүлэх;
- Нийгмийн хамгааллын хүртээмж, нөөцийн (халамжийн үйлчилгээнүүд болон орон нутагтаа хүртэж болох бусад үйлчилгээ зэрэг) талаар мэдээлэл өгөх;
- Бусад хүүхдийн эцэг эхчүүдтэй танилцаж нөхөрлөхөд дэмжлэг үзүүлэх

1.3.3 Холбон зуучлах дэмжлэг

Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй эсэхээс нь үл хамааран, хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж, олон хүүхэдтэй хамт байлгах нь чухал. ЭХХХ-т хамруулснаар тухайн хүүхдийг цэцэрлэгт хамруулах, цэцэрлэгийн өдөр тутмын үйл ажиллагаанд бусад хүүхдийн адил оролцдог болоход нь дэмжлэг үзүүлдэг. Ингэхдээ асран хамгаалагч нь ямар цэцэрлэгт хүүхдээ оруулах хүсэлтэй байгааг тодруулж, цэцэрлэгийн талаар мэдээлэл өгнө. Мөн багш нь хүүхдийн хөгжлийг үнэлж, тэрхүү мэдээллээ цэцэрлэгт нь танилцуулж зуучлах нь үр дүнтэй дэмжлэг болдог.

1.4 ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГАЧЛАЛ

1.4.1 Зорилтот хүүхэд болон асран хамгаалагч

ЭХХХ-т хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй, цэцэрлэгт хараахан хамрагдаагүй байгаа хүүхдийг хамруулдаг.


18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн товлалт үзлэгээр хөгжлийн хоцрогдолтой байж болзошгүй гэж үзсэн хүүхдийн хөгжлийг дэмжих нэмэлт хөтөлбөр болгон 18 сартайгаас 36 сар хүртэлх насны хүүхдийг хамруулж болно.

1.4.2 Гол хэрэгжүүлэгч

Аймаг, дүүргийн нөхцөл байдлыг судлан үзсэний үндсэн дээр боломжиндоо тохируулан ЭХХХ-ийг хэрэгжүүлэх тогтолцоо, зохион

байгуулалтын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай. Ингэхдээ нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн байгууллагуудын хамтын ажиллагаа, салбар дундын уялдааг хангаж ажиллах шаардлагатай тул эдгээр салбарыг нэгдсэн удирдлагаар хангадаг аймаг дүүргийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс/Нийгмийн хөгжлийн хэлтэс байх нь тохиромжтой. Нийгмийн бодлогын хэлтэс/Нийгмийн хөгжлийн хэлтэс нь аймаг, дүүрэгтээ Салбар комисс болон Эрүүл мэндийн газар/Эрүүл мэндийн төв, цэцэрлэг, ТББ-уудын хоорондын зохицуулалтыг хийж, ЭХХХ-ийг зохион байгуулна. Дараах зурагт Хөвсгөл аймаг дахь ЭХХХ-ийн тогтолцооны жишээг үзүүлэв.

Бүдүүвч 2. Хөвсгөл аймагт ЭХХХ-ийг хэрэгжүүлж буй тогтолцоо



1.4.3 Төсөв

ЭХХХ-г ашиглах хэрэглэгдэхүүнийг худалдан авах зардал болон багшид олгох урамшууллын зардлыг төсөвлөнө.

ЭХХХ-ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хэрэглэгдэхүүнийг худалдан авах зардалд 1,000,000 орчим төгрөг зарцуулагдсан болно. (2018 онд)

1.4.4 Багш

Нэг ээлжинд хөтөлбөрт 10 орчим хүүхдийг эх, эцгийн аль нэгний хамт оролцуулж, 3-4 багш ажиллана.

Багшаар цэцэрлэгийн багш зэрэг бага насны хүүхэдтэй ажиллах туршлагатай хүнийг сонговол тохиромжтой тул багш нарын багт наанадаж нэг цэцэрлэгийн багшийг заавал оруулах нь зүйтэй. Бусад багшаар сургуулийн багш, сэтгэл зүйч, хөдөлгөөн засалч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны гишүүн зэрэг янз бүрийн мэргэжлийн хүмүүсийг ажиллуулж болно. Багш заавал хөгжлийн бэрхшээлийн талаар мэдлэг, туршлагатай байх ёстой гэж хатуу шаардлага тавихгүй.

1.4.5 Хамрах хүрээ

Хөтөлбөрийн нэг ээлжинд 10 орчим хүүхдийг асран хамгаалагчдын хамт хамруулна.

1.4.6 Давтамж, хугацаа

Хөтөлбөрийг сард 1 удаа, нийт 6 удаагийн арга хэмжээг “Нэг ээлж” гэж тооцон зохион байгуулна. Зарчмын хувьд, нэг хүүхэд 6 удаа хөтөлбөрт оролцох ёстой хэдий ч хамрагдах цэцэрлэг болон хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээ хараахан тодорхой болоогүй тохиолдолд хүүхдийг хөтөлбөрт үргэлжлүүлэн хамруулах эсэхийг ярилцаж шийвэрлэнэ.

Хөтөлбөрийг зохион байгуулахдаа хүүхдүүдээ авч ирэх оролцуулах хамгийн боломжтой цагийг гэр бүлтэй нь тохиролцон сонгоно. Бага насны ихэнх хүүхдүүд өдөр унтдаг тул үдээс өмнө 10-11 цагийн хооронд байвал тохиромжтой.

1.4.7 Зохион байгуулах газар

Байршлын хувьд аль болох эх, хүүхдүүд ирж оролцоход дөхөм байх хэрэгтэй.

Хөтөлбөрийн өрөө нь хүүхдүүд чөлөөтэй хөдөлж тоглох боломжтой, уужим зайтай байна (20 кв.м-ээс доошгүй)

Өрөөнд шаардлагагүй тавилга, хэрэгслийг байлгахгүй байх, эсвэл хүүхдэд харагдахгүй байхаар далдалж аюулгүй байдлыг хангах нь чухал.

Зураг 1. Зохион байгуулах танхим



2

ЭХ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ ЯВЦ

2.1 БЭЛТГЭЛ ХАНГАХ

2.1.1 Хэрэгжүүлэх тогтолцоо ба хариуцан зохион байгуулах байгууллагыг сонгох

“1.4.2 Гол хэрэгжүүлэгч” хэсэгт тэмдэглэсэнчлэн ЭХХХ-ийг хэрэгжүүлэх тогтолцоо, зохион байгуулалтын асуудлыг судалж шийдвэрлэх ба холбогдох байгууллагуудыг оролцуулан хэрэгжүүлэх үндэслэл, агуулгын талаар танилцуулж, байгууллагуудын хариуцах үүргийг тодорхой болгоно.

(Байгууллагуудын хариуцах чиг үүргийн жишээ)

- Салбар комисс: Ерөнхий зохицуулалт, хяналт удирдлагаар хангах, хөтөлбөрт хамрагдах гэр бүлтэй холбоотой мэдээллүүдийг нэгтгэх
- Боловсрол соёл, урлагийн газар/Боловсролын хэлтэс (Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн) болон цэцэрлэгүүд: Хөтөлбөр зохион байгуулах өрөө, байрыг хариуцах, багш томилох
- Эрүүл мэндийн газар/Эрүүл мэндийн төв: Өрх, сумын эрүүл мэндийн төвийн ажилтнууд 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгээр хөгжлийн хоцрогдол нь илэрсэн болон хөгжлийн дэмжлэг шаардлагатай 3 хүртэлх насны хүүхдийг гэр бүл, асран хамгаалагчтай нь зөвлөлдсөний үндсэн дээр ЭХХХ-т хамруулахын тулд хөтөлбөрийн зохион байгуулагчидтай холбон зуучлах ба хөтөлбөр явагдах товлосон цагийг хүүхдийн гэр бүлтэй холбоо барьж, зарлаж мэдэгдэх

2.1.2 Багш томилох

Холбогдох байгууллагуудтай хамтран багш нарыг (3-4 хүн) сонгоно.

Эрхэлсэн ажилтай хүнийг багшаар сонгох тохиолдолд ажлын байрны тодорхойлолтод нь ЭХХХ-ийн ажил үүргийг нэмж тусгана.

2.1.3 Багш нарыг сургах

Энэхүү зөвлөмжийг ашиглан багш нарт сургалтыг зохион байгуулна.

2.1.4 Хэрэглэгдэхүүн бэлтгэх

ЭХХХ-т зайлшгүй шаардлагатай хэрэглэгдэхүүнүүд: Эвлүүлдэг дэвсгэр, хийлдэг усан сан, тоглоомон хонгил, олон өнгийн бөмбөгнүүд, хөгжим тоглуулагч, бусад хайчилбар дүрсүүд зэрэг багтана.

Хөвсгөл аймагт ЭХХХ-ийг хэрэгжүүлэхэд худалдан авсан хэрэглэгдэхүүний төсвийг дараах хүснэгтэд жишээ болгож харууллаа.

Хүснэгт 1. Хэрэглэгдэхүүн худалдаж авахад зарцуулагдсан төсөв

	Хэрэглэгдэхүүн	Төсөв (Төгрөг)
1	Эвлүүлдэг дэвсгэр	400,000
2	Хийлдэг усан сан	60,000
3	Тоглоомон хонгил	60,000
4	Бүртгэл хийхэд зориулсан том модны дүрс	30,000
5	Олон өнгийн бөмбөгнүүд	25,000
6	CD, хуурцаг тоглуулагч (Хөгжим)	170,000
7	Харилцах дэвтэр болон бусад зүйлс (Бөмбөг хураах хайрцаг, хайчилбар зураг, зургийн ижлийг олох карт, цэцгээр чимэглэсэн титэм, хөдөлгөөнт тоглоомын хэрэгслүүд г.м)	255,000
	Дүн	1,000,000

Зураг 2. Хэрэглэгдэхүүний жишээ

Дэвсгэр (Хивс байж болно)	Хийлдэг усан сан	Тоглоомон хонгил
		
Бүртгэл хийхэд зориулсан том модны дүрс	Олон өнгийн бөмбөгнүүд	Бөмбөгнүүд хураах хайрцаг
	 	

Хайчилбар зургийн ижлийг олох карт	Цэцгээр чимэглэсэн титэм
	
Хөдөлгөөнт тоглоомын хэрэгслүүд	
 <div data-bbox="819 733 1081 856" style="border: 1px solid black; padding: 5px;"> <p>Эхлэх байрлалыг нь ойлгомжтой болгох үүднээс хөлийн мөрний тэмдэг байрлуулах</p> </div>	

Харилцах дэвтэр

“Харилцах дэвтэр” нээн ашиглах нь гэр бүл, асран хамгаалагчидтай харилцах хэрэгсэл болдог. Уг дэвтэрт ЭХХХ дэх тоглоомын аргуудын талаар дэлгэрэнгүй тайлбарласан. Мөн тухайн өдрийн хөтөлбөрт оролцсон хүүхдийн байдал, багшийн зөвлөгөө зэргийг тэмдэглэн асран хамгаалагчид өгдөг. Асран хамгаалагч дараагийн хөтөлбөр хүртэл хүүхдийнхээ өдөр тутмын байдал, сэтгэл зовж буй асуудал, асууж тодруулах зүйл зэргийг бичиж тэмдэглээд, хөтөлбөрт ирэхдээ багшид өгнө. ЭХХХ-ийг зохион байгуулахаар төлөвлөсөн бол Хавсралт 1-ийн “Харилцах дэвтэр”-ийг хуулбарлан ашиглаж болно.

Зураг 3. Харилцах дэвтэр



2.1.5 Зорилтот хүүхдийг сонгох, холбоо барих

Эхлээд ЭХХХ-т хамруулах хүүхдүүдийг сонгон оролцогчдын бүртгэлийг хөтөлнө.

Зорилтот хүүхдийг сонгохдоо, Эрүүл мэндийн газар/Эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллах шаардлагатай. Тухайлбал, Өрх, сумын эрүүл мэндийн төвөөс 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгээр хөгжлийн хоцрогдолтой нь илэрсэн болон хөгжлийн дэмжлэг шаардлагатай 3 хүртэлх насны хүүхдийн мэдээллийг Эрүүл мэндийн газар/Эрүүл мэндийн төвд нэгтгэсний дараа, ЭХХХ-ийн гол хэрэгжүүлэгч Нийгмийн бодлогын хэлтэс/Нийгмийн хөгжлийн хэлтэст хүргүүлнэ.

ЭХХХ-т хамруулах хүүхдүүдийн жагсаалт бэлэн болмогц, гол хэрэгжүүлэгч байгууллагаас ирүүлсэн чиглэлийн дагуу багш нар болон эрүүл мэндийн байгууллага тухайн хүүхдүүдийн гэр бүлтэй нь холбогдож, ЭХХХ-ийн талаар тайлбарлан хүүхэдтэйгээ хамт оролцохыг урина.

Асран хамгаалагч нь хүүхдийнхээ хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг хүлээн зөвшөөрөхгүй байх тохиолдол гардаг тул “Танай хүүхэд хөгжлийн хоцрогдолтой (эсвэл хөгжлийн бэрхшээлтэй) байна. Тиймээс хүүхдээ ЭХХХ-т хамруулах хэрэгтэй” гэх мэтээр шууд хэлж болохгүй. Харин хүүхэдтэйгээ хамт ЭХХХ-т хамрагдвал, илүү хөгжүүлэх боломжтой гэдгийг эелдгээр тайлбарлаж ойлгуулах нь зүйтэй.

Мөн хөтөлбөр зохион байгуулах өдрөөс өмнө асран хамгаалагчидтай холбоо барьж, оролцох боломжтой эсэхийг тодруулна. Ингэж урьдчилан холбоо барих нь хамрагдалтыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг.

2.2 ТУХАЙН ӨДРИЙН ХӨТӨЛБӨР

Нэг удаагийн ЭХХХ-ийг дараах байдлаар зохион байгуулна.

Хүүхдүүдэд өдөр унтах боломж олгохын тулд үдээс өмнө зохион байгуулбал тохиромжтой.

Дараах хүснэгтэд тоглоом, хөтөлбөрийн цагийг жишээ болгон тэмдэглэсэн бөгөөд хүүхдүүдийн оролцож тоглож буй байдлаас нь хамааран уян хатан байдлаар өөрчлөх боломжтой юм.

Хүснэгт 2. ЭХХХ-ийн үйл ажиллагаа төлөвлөлт (Үдээс өмнө 10 цагт эхлүүлэх жишээ)

09:00	<u>Бэлтгэл хангах</u> <ul style="list-style-type: none">- Өрөөгөө бэлтгэх- Хүүхдүүдийн сар бүрийн тэмдэглэлийн маягтыг ашиглан өмнөх удаад оролцсон байдал, үзүүлсэн дэмжлэгийг хүүхэд бүрээр эргэж нягтлах
10:00-10:20	<u>Цуглах, бүртгэх</u> <ol style="list-style-type: none">1. Хайчилбар зургийн ижлийг олж модонд наах2. Бөмбөгөөр чөлөөтэй тоглох
10:20-11:00	<u>Үндсэн хөтөлбөр</u> <ol style="list-style-type: none">3. Мэндчилгээ (Хүүхэд бүрийг нэрээр нь дуудаж хариу үйлдэл хийлгэх)4. Хөдөлгөөнт дуу “Гоёо-гоёо” (Тоглоом бүрийн дараа давтана)5. Цаасаар тоглох “Гоёо гоёо” дуу6. Хөдөлгөөнт тоглоом (Тоглоомон хонгил, саадтай зам, шулуун зам) Хөдөлгөөнт дуу “Гоёо-гоёо”7. Харилцаж тоглох Хөдөлгөөнт дуу “Гоёо-гоёо”8. Мэндчилгээ
11:00~	<u>Тарахын өмнө</u> <ul style="list-style-type: none">- Багш асран хамгаалагчтай ганцаарчлан уулзаж зөвлөгөө өгөх- Асран хамгаалагчид хоорондоо чөлөөтэй ярилцах
Хөтөлбөрийн дараа 1 цаг орчим	<u>Дүгнэлт хэлэлцүүлэг</u> <ul style="list-style-type: none">- Хүүхдийн “Сар бүрийн тэмдэглэл”-ийн асуултын дагуу оролцсон хүүхэд бүр дээр дүгнэлт хийж, дэмжлэгийн чиглэлээ хэлэлцэх- Хэлэлцүүлгийн агуулга, үр дүнг “Хүүхдийн мэдээлэл”-д тэмдэглэх

2.3 ҮНДСЭН ХӨТӨЛБӨРИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

Үндсэн хөтөлбөр нь эцэг эх, хүүхдийг хамтад нь тоглуулах аргад суурилах ба энэ нь эцэг эх, хүүхдийн хооронд илүү сайн харилцаа үүсгэх, улмаар бага насны хүүхдийн хөгжлийн чухал хэсэг болох “бусад хүнтэй харилцах” болон “аливаа зүйлтэй нүүр тулах” орчин нөхцөлийг бий болгоход чиглэдэг. Мөн ЭХХХ-ийн тоглоомын аргаар гэртээ ч тоглох боломжтой учир гэртээ байхдаа хүүхэдтэйгээ аль болох их харилцаж, хамт тоглохыг гэр бүл, асран хамгаалагчид нь зөвлөөрэй.

2.3.1 Үндсэн хөтөлбөрийг зохион байгуулахад анхаарах зүйл


- Үндсэн хөтөлбөр болох тоглоомыг хүүхдийн хөгжилд нийцүүлэн зохион байгуулна. Хүүхэд тоглоомонд оролцохгүй, дургүйлхэж уйлаад байвал албадаж болохгүй. Харин ийм хүүхдийг орчинд нь дасгахдаа зөнд нь байлгаад бусад хүүхдүүдийн тоглож буйг харуулахад хангалттай. Хөлд ороогүй, эсвэл сайн алхахгүй байвал асран хамгаалагч нь өвөр дээрээ авч оролцуулж болно.
- Нэг ээлжийн 6 удаагийн хөтөлбөрт төлөвлөсөн тоглоомын аргуудыг явцын дунд өөрчлөхгүй байхыг хичээгээрэй. Учир нь нэг үйлдлийг олон удаа давтах нь хүүхдийг хөгжүүлэхэд чухал нөлөөтэй бөгөөд ижил хөтөлбөрөөр олон дахин тоглуулснаар, багш нар болон эцэг эхчүүд тухайн хүүхдийн хөгжилд гарч буй ахиц, өөрчлөлтийг мэдэх боломжтой.
- Тоглоом бүрийн эхэнд чиглүүлэгч тухайн тоглоомыг тайлбарлаж өгөх хэрэгтэй. Жишээ нь, “одоо бүгдээрээ найган ганхах цэцэг болж тоглоё” гээд өөрөө хийж үзүүлнэ.
- Тоглоом бүрийн эхлэл болон төгсгөл нь хүүхдэд ойлгомжтой байхад анхаарна. Жишээ нь чиглүүлэгч “Сая бүгд их сайн оролцсон. Харин одоо дараагийн тоглоомоо эхэлье”, “Дараа нь яаж тоглох билээ” гэх мэтчилэн хэлж, тоглоомын эхлэл, төгсгөлийг тодорхой болгож өгөх хэрэгтэй.

2.3.2 Чиглүүлэгч болон бусад багш нар

Багш нар өөрсдийн дундаас чиглүүлэгчээр ажиллах хүнийг сонгоно. Чиглүүлэгч нь тоглоомын явцад хүүхдүүдийн анхаарлыг өөртөө хандуулах чадвартай байх ёстой бөгөөд хүүхдүүд болон асран хамгаалагчдад харагдахуйц байрлалд сууж тоглоомыг хөтлөн явуулна.

Харин бусад багш нар чиглүүлэгчид туслах үүрэгтэй оролцож, ганцаарчлан дэмжлэг үзүүлэх шаардлагатай хүүхэд болон асран хамгаалагчид ойр суун хэрхэн тоглохыг үлгэрлэж үзүүлэх зэргээр тэдэнд тусална.

Бүдүүвч 3. Чиглүүлэгч болон бусад багш нарын байрлал



2.3.3 Тоглоом, үйл ажиллагаа бүрийн тайлбар

“2.2 Тухайн өдрийн хөтөлбөр” хэсгийн Хүснэгт 2-т тэмдэглэсэн 1-8 дахь ажиллагаа, тоглоомын аргуудыг тайлбарлав.

➤ Зургийн ижлийг олж модонд наах

Энэ нь ЭХХХ-т ирсний дараа хийх хамгийн эхний үйл ажиллагаа юм. Хүүхэд орчиндоо дасч, дургүйцэж уйлахаа больсны дараа хийлгэвэл зохистой.



Хүүхэд хэд хэдэн хайчилбар зургаас дуртайгаа сонгож аваад, картын ижил зураг дээр байрлуулна. Хайчилбар зурагнуудыг хүүхдэд ойртуулаад таалагдсан зургийг нь сонгуулдаг.

Зорилго: Ижил төстэй зураг, дүрсийг таних чадвар болон хэл яриаг ойлгох чадварыг хөгжүүлнэ.



Сонгосон хайчилбар зургийг модонд наах.

Зорилго: Бусдын зааврыг ойлгох чадвар болон хөдөлгөөнөө удирдах чадварыг нь сайжруулж, хөдөлгөөний чадварыг нь хөгжүүлнэ.

➤ Бөмбөгөөр тоглох

Үндсэн хөтөлбөрийг эхлүүлэхийн өмнө хүүхдүүдийг чөлөөтэй тоглуулна. Ямар ч хүүхдийн хувьд сонирхолтой тоглоом болох бөмбөгөөр чөлөөтэй тоглуулах явцдаа хүүхдүүдийн анхаарлыг чиглүүлэгч өөртөө хандуулна. Гол нь чиглүүлэгч хүүхдүүдийг өөртэйгөө харилцуулах зорилготой. Харин бусад багш нар асран хамгаалагчтай ярилцан, хүүхэд нь гэртээ ямар байсан болон тэдний төлөө сэтгэл зовниж буй аливаа асуудал байгаа эсэх талаар асууж зөвлөгөө өгнө.



Бөмбөг шидэж, өнхрүүлж харилцаж тоглоно.

Зорилго: Багштай бөмбөгөөр харилцаж тоглон хүүхдийн бусадтай харилцах суурь чадварыг хөгжүүлнэ.



Тоглож дуусаад бөмбөгөө хураана.

Зорилго: Хүүхэд өөрийн тоглосон тоглоомоо хурааж, цэгцлэх дадалд суралцана.

➤ Мэндчилгээ



Үндсэн хөтөлбөр эхэлснийг мэдэгдсэний дараа хүүхэд бүрийг нэрээр нь дуудан хариу үйлдэл хийлгэнэ.

Зорилго: Хүүхдүүдэд үндсэн хөтөлбөр эхлэх гэж буйг ойлгуулаад, анхаарлыг нь чиглүүлэгчид хандуулна. Нэрийг нь дуудахад хариу үйлдэл үзүүлж сургана.

➤ Хөдөлгөөнт дуу “Гоёо-гоёо”

Хөдөлгөөнт дууг нэг тоглоомоос нөгөөд шилжихийн өмнө удаашруулсан хэмнэлээр дуулна. Нэг дууг олон давтамжтай дуулах нь тоглоом тус бүрийг зааглаж ойлгуулахын зэрэгцээ хүүхдийн анхаарлыг дараагийн хэсэгт хандуулах зорилготой байдаг. Мөн хүүхэд багшийн үг, үйлдэлд төвлөрч, дууны хөдөлгөөнийг дуурайж хийж чаддаг болгохыг зорино.



Дуу болон аяны хэмнэлд тааруулан гар, биеэ хөдөлгөн тоглоно.

Зорилго: Хүүхдийн сонсох, харах, хүрэлцэх мэдрэхүйг цочроон нүд, чих, арьс, булчин зэрэг мэдрэхүйн эрхтнээс гадна, цочроолтыг хүлээн авах тархи болон хариу үйлдэл үзүүлэх бие, эрхтний хөгжлийг дэмждэг. Түүнчлэн бага насны хүүхдийн хамгийн дотны хүн болох ээж нь хүүхэдтэйгээ дуулж харилцан, магтаж эрхлүүлэх нь хүүхдийн харилцааны чадвар болон хэл ярианы суурь чадварыг сайжруулдаг.

➤ Цаасаар тоглох-1 “Цаас урж тоглох, хурааж цэгцлэх”

Хүүхэд, ээж болон багштай хамтран гар хурууныхаа булчинг бүрэн ашиглаж цаас урж тоглоно. Ингэхдээ сонингийн цаас ашиглаж болно. Ээж нь хүүхэддээ хэрхэн заах арга барил эзэмших ба хүүхэд нь ээжийгээ дуурайж цаас урж жижиглэнэ. Эхэн үед хүүхэд ээжийнхээ өвөр дээр сууж цаас урж хийх ба аажимдаа өөд өөдөөсөө харж сууж тоглодог болохыг зорино.



Хэрэггүй, хуучин сонингийн цаасыг гар, хурууны булчингийн тусламжтайгаар урж жижиглэх ба тоглож дууссаны дараа чимхэх, базаж авах зэргээр уутанд хурааж хийнэ.

Зорилго: Цаасыг чимхэх, базах, урж тасдах, сэгсрэх зэргээр зугаацан тоглох нь гар хурууны нарийн чимхлүүр хөдөлгөөнийг хөгжүүлдэг. Мөн цаасыг барьж хөдөлгөхөд гарах дуу чимээг сонсох, хэлбэр болон хөдөлгөөн нь хэрхэн өөрчлөгдөж буйг харах, улмаар шүргэх, атгаж авах зэргээр хүртэх болон бусад мэдрэхүйг нь цочроож, сэдээх зорилготой.

➤ Цаас урж тоглох-2 “Хийлдэг усан сан дотор цаасаар тоглох”

Урж жижиглэсэн цааснуудыг их хэмжээгээр урьдчилан бэлтгэж усан сан дотор асгаж тоглоно.



Хүүхдүүд усан сан дотор орж, урж жижиглэсэн их хэмжээний цаасаар тоглоно.

Зорилго: Энэ тоглоомоор хүүхдийн мэдрэхүйнүүдийг цочроож, сэдээнэ. Хүүхэд их хэмжээний цаас болон түүнийг хөдөлгөхөд гарах чимээ, эргэн тойрны олон хүний нөлөөнөөс болж эхэндээ уйлах тохиолдол байдаг ч аажимдаа ээжтэйгээ хамт байхдаа айж, бишүүрхэлгүйгээр усан сан дотор орж, цаасаар зугаацан тоглодог болохыг зорино.

➤ Цаас урж тоглох-3 “Цаасан шүхрээр тоглох”

Сонингийн цаасаар аль болох том хэмжээний шүхэр хийн, бүх оролцогчдыг шүхэрний дор төвлөрүүлж суулган тоглоно.



Хэрэглэхгүй сонингийн цаасыг хооронд нь нааж том шүхэр мэт болгоод хүүхдүүдийн дээрээс ойртуулж, холдуулах зэргээр дээш доош сэвж тоглоно.

Зорилго: Хүүхдийн мэдрэхүйнүүдийг цочроож сэдээнэ. Энэ тоглоом нь дуу чимээ болон өндөр нам, салхины (агаарын урсгал) хөдөлгөөн, дээш доош нь сэвэхэд гэрэл гэгээ хэрхэн өөрчлөгддөг талаар хүүхдүүдийг зугаацуулангаа ойлгуулж мэдрэхүйнүүдийг сэдээх цочроох, сэргээх зорилготой. Эхний үед хүүхэд шүхрээс айж, уйлах тохиолдол гардаг ч, ээжтэйгээ хамт байвал тайвширч шүхэр доор тайван сууж, хөөрөн тоглож сургахад анхаарна.

➤ Хөдөлгөөнт тоглоом (Тоглоомон хонгил, саадтай зам, шулуун зам)

Энэ насны хүүхдүүдийн эзэмших шаардлагатай алхах, бие даан явах чадварыг хөгжүүлэхийн тулд янз бүрээр алхах үйлдлийг тойрог байдлаар ээлж дараатай, тодорхой давтамжтайгаар хийж тоглоно. Хүүхдүүд хонгилоор мөлхөж гараад, нарийн шулуун замаар тэнцвэрээ олж алхан, саадтай замыг давж явна. Хүүхдүүдийг тухайн үйлдлүүдийг бага багаар дэс дараатай, тойргоос хазайж гаралгүйгээр өөрийн ээлжийг тэвчээртэй хүлээж хийж чаддаг болгохыг зорино.



Хүүхэд эцэг эхтэйгээ тоглоомон хонгилоор, саадтай зам, шулуун зам бүхий хөдөлгөөнт тоглоомоор тоглоно. Хэрэглэгдэхүүн тус бүрийн өмнө хөлийн мөрний тэмдэг байрлуулах ба хүүхэд тус тэмдэг дээр зогсон багшийн “Манай, бэлэн үү?” гэсэн асуултад “тийм” гэсэн хариу өгсний дараа үйлдлийг гүйцэтгэнэ.

Зорилго: Хүүхдүүдийн энэ насанд нь хөгжүүлэх шаардлагатай биеийн хөдөлгөөнүүдийг хийлгэж тоглуулснаар тэдний хөдөлгөөний чадварыг хөгжүүлдэг. Түүнчлэн ийнхүү бүх биеэрээ хөдлөх нь тэдний хэл яриа болон сэтгэл зүйн хөгжилд ч чухал үүрэгтэй юм.

➤ Харилцаж тоглох

Энэ нь эх хүүхдийн хоорондын итгэлцэл, эрхэлж наалдах харилцаанд суурилсан бие биедээ хүрэлцэж, харилцан тоглох үйл ажиллагаа юм. Ээж нь суугаагаараа хүүхдээ өвөр дээрээ зогсоон, үндсэн багшийн хэлэх үг, үзүүлэх хөдөлгөөнийг дуурайж “цэцэг томоос том ургалаа”, “цэцэг салхинд ганхан найгалаа” гэх зэргээр хүүхэдтэйгээ хамтдаа найган хөдөлж тоглоно.



Ээж хүүхэдтэйгээ ижилхэн цэцэг чимэглэлтэй титэм зүүгээд өөрсдийгөө цэцэг гэж төсөөлөн цэцэг ургаж өндөр болж байгаа мэтээр хүүхдээ дээш нь өргөх, салхины аясаар ганхаж буй мэт өөрийн биеийн хөдөлгөөнөөр дагуулан найгуулах зэргээр тоглоно. Тоглож дуусаад газарт унасан цэцэг навчийг түүж модонд наах ба хүүхэд хаана, юуг хэрхэн хийхээ өөрөө ойлгож гүйцэтгэнэ.

Зорилго: Энэ тоглоомын үед хүүхдийн олон мэдрэхүйг цочроох, тэнцвэрээ хадгалах зэрэг хариу үйлдэл үзүүлэх чадварыг нь хөгжүүлнэ. Ээж хүүхэдтэйгээ бүх биеэрээ харилцаж, эх үрийн харилцаа улам дотносон ойртоно.

➤ Хөтөлбөрийн төгсгөлийн мэндчилгээ

Энэ үед дахин нэг удаа “Гоёо-гоёо” дууг дуулж, хүүхдүүдийн анхаарлыг чиглүүлэгчид хандуулан, энэ өдрийн үйл ажиллагаа дуусах гэж буйг ойлгуулна. Дуулж дуусаад хүүхэд бүрийг нэрээр нь дуудаж, энэ өдрийн үйл ажиллагаанд хэрхэн хичээж, идэвхтэй оролцсон талаар ээж, хүүхдэд урмын үг хэлнэ. Тухайлбал “Манай....Туяа өнөөдөр хөдөлгөөнт тоглоомд эхнээс нь дуустал маш сайн хичээнгүйлж оролцсон” гэх мэт.

2.4 БАГШ НАРЫН ЧИГ ҮҮРЭГ

2.4.1 Багш нарын анхаарах зүйл

Багш нар ЭХХХ-ийг хөтлөн явуулахдаа дараах зүйлийг анхаарах шаардлагатай.

- Хүүхдийг хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй гэдэг нүдээр харах бус, бусадтай адилхан хүүхэд, хувь хүн гэж харилцах чухал.
- Ямар ч тохиолдолд хүүхдэд урам өгч магтах нь хүүхдийн шинэ үйлдэл хийж үзэх, туршиж үзэх хүслийг төрүүлэх бөгөөд энэ нь тухайн хүүхэд хөгжихөд тустай.
- Асран хамгаалагчийг (гэр бүл) нь хүүхдээ ойлгож, хүүхдээ хөгжүүлэх чадварт сургахын тулд тэднийг дэмжиж ажиллах хэрэгтэй. Үүний тулд асран хамгаалагчийн сэтгэлийг зовниулсан асуудлуудыг нь сонсож зөвлөгөө өгөхийн сацуу тоглоомын явцад хүүхдийн чадаж байгаа зүйл, сайн талыг нь хэлэнгээ зугаатай, хөгжилтэй дурсамжийг асран хамгаалагчидтай хуваалцах нь зүйтэй. Асран хамгаалагчийг буруутгаж үгүйсгэж болохгүй, харин тэдний бодол, санааг ойлгож байгаагаа мэдрүүлэх нь чухал.
- Асран хамгаалагчдын асуултад эелдэг, ойлгомжтой хариулахыг хичээх ба тэр даруй хариулт өгөх боломжгүй асуулт байвал, хэдийд хариулж ярилцаж болох тухайгаа тайлбарлаж, аль болох ойрын хугацаанд хариулахыг хичээх нь зүйтэй.

2.4.2 Багш нарын чиг үүрэг

Багш нар дараах гол 2 үүрэгтэй.

1) ЭХХХ-ийг чиглүүлэх, зохион байгуулах

- Оролцогчидтой холбоо барих: 1) Хөтөлбөрт хамруулахаар тогтсон хүүхдийн асран хамгаалагчтай холбоо барьж, ЭХХХ-ийн тухай тайлбарлан оролцохыг зөвшөөрүүлэх, 2) Хөтөлбөр зохион байгуулахаас хэд хоногийн өмнө нэг бүрчлэн утсаар холбоо барьж, оролцохыг урих

- Урьдчилсан бэлтгэл хангах (өрөө бэлтгэх): Хэрэглэгдэхүүнүүдийнхээ бүрэн бүтэн байдлыг шалгах, өрөөг засаж бэлтгэх
 - Хөтөлбөрийг зохион байгуулах
- 2) Хүүхэд, тэдний гэр бүлд хөгжлийн үнэлгээ хийх, хөгжлийн дэмжлэг үзүүлэх
- Хөтөлбөрийн явцад: Хүүхэд нэг бүрийн хөтөлбөрт оролцож буй байдалд ажиглалт хийх. Мөн асран хамгаалагчаас нь хүүхдийн гэр орондоо байдаг байдал, асран хамгаалагчийн сэтгэл зовнисон асуудал зэргийг асууж тодруулах.
 - Хөтөлбөрийн дараа: Хүүхдийн сар бүрийн тэмдэглэл дэх асуумжийн дагуу хүүхэд нэг бүрийн хөтөлбөрт оролцсон байдал, үзүүлэх дэмжлэгийг хэлэлцэх
 - Үзүүлэх дэмжлэгтээ тулгуурлан хүүхэдтэй ажиллах арга болон цэцэрлэгт хэрхэн хамруулах талаар асран хамгаалагчдад зөвлөгөө өгөх
 - Цэцэрлэгт холбон зуучлах дэмжлэг болгож асран хамгаалагчаас зөвшөөрөл авсны үндсэн дээр хүүхдээ хамруулахыг хүссэн цэцэрлэгт нь хүүхдийн ЭХХХ-т оролцсон байдлын (хүүхдийн сайн тал, анхаарах зүйл зэрэг) талаар мэдээлэл өгөх.

2.5 АНХААРАХ ЗҮЙЛ

2.5.1 Мэдээлэл цуглуулах, ашиглах

Хувь хүний мэдээллийг ашиглах бол анхаарал болгоомжтой хандах шаардлагатай.

ЭХХХ-ийг зохион байгуулах явцад цуглуулсан хүүхэд, гэр бүлийн талаарх мэдээлэл, гэрэл зураг зэргийг ЭХХХ-өөс өөр зорилгоор эсвэл бусад байгууллагад (цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллага г.м) дамжуулах болон зарлаж болохгүй.

“Хүүхдийн мэдээлэл”-ийн тухайд, Гол хэрэгжүүлэгчээс тогтоосон журмыг үндэслэн зохистой ашиглахад анхаарах шаардлагатай. (ялангуяа мэдээллийг хадгалах арга, газар, хугацааг тодруулах)

2.5.2 Ажиглагчдын тухай

Хөтөлбөртэй танилцахаар ирсэн ажиглагчдад зураг авах, дүрс бичлэг хийхгүй байхыг хатуу анхааруулна.

Мөн хүүхдүүдийг тоглоом, үйл ажиллагаанд оролцоход нь саад болохгүйн тулд ажиглагчдын суудлыг хүүхдүүдээс хол суулгана.

ХАВСРАЛТ 1

Харилцах дэвтэр



Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл

“ЭХ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР”



ХАРИЛЦАХ ДЭВТЭР

Овог Нэр

Нас Хүйс



Ээж аав та бүхнийг “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-т хүүхдийнхээ хамт идэвхтэй оролцож тэднийхээ хөгжлийг дэмжсэж байгаа санаачилгад талархал илэрхийлье. Та энэхүү “Харилцах дэвтэр”-т хүүхдийнхээ хөгжил, өсөлт бойжилтод гарч буй аливаа асуудлуудыг тухай бүр бичиж тэмдэглэн хөтөлбөрийг явуулж байгаа багш нартай чөлөөтэй харилцаж, санал бодлоо хуваалцаж байгаарай.

Ингэснээр таны хүүхэд юу хийх дуртай, юу чадаж байгааг тухай бүр тогтоож, цаашид яаж сайжруулах, хөгжүүгдэх талаар хамтран шийдэх боломжтой. “Харилцах дэвтэр”-ээ үргэлж ашиглаж, хаяж гээлгүй нандигнан хадгална уу.



Хайчилбар зургийн ижлийг тохирдуулах



Хүүхдэд хэд хэдэн хайчилбар зургаас дургатайгаа сонгон авч, картны ижил зураг дээр тааруулан байрлуулахыг зааж өгнө. Ингэх нь хүүхдийн харааны мэдрэхүйгээрээ ижил төстэй дүрсийг таних чадвар, хүний ярьж байгааг ойлгох чадварыг хөгжүүлэх ба хүүхэд ямар зүйлийг илүү анхаарч, сонирхож байгааг мэдэн сонирхлыг нь улам бүр тэлэх боломжтой.

Та сард “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-г оролцсон тухай сэтгэгдлээ хуваалцана уу.



A large rectangular box with rounded corners and horizontal dashed lines for writing.

Та хүүхлээ өстөж бойжуулахад тулгамдаж байгаа асуудал болон зөвлөгөө авахыг хүсэж буй зүйлээ чөлөөтэй гэмдэглээрэй.

A large rectangular box with rounded corners and horizontal dashed lines for writing.

Хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцож буй байдал ба хүүхдийн хөгжлийн ахицын талаарх багшийн гэмдэглэл.


A series of ten horizontal dotted lines for writing. Each line contains a small illustration of an object: a clownfish, a bicycle, a beach ball, a water bottle, a clownfish, a beach ball, a water bottle, a bicycle, a clownfish, and a bicycle.

Хайчилбар зүргийг мөлдөд наах



Хүүхдэд сонгосон зургаа мөлдөд наахыг зааж өгнө. Эхлээд ээж өөрөө хийж үзүүлэх ба хүүхдийг дагаж хийлгүүлнэ. Энэ үйлдлээр дамжуулан, хүүхэд бусдын зааврыг ойлгох болон өөрийн хөдөлгөөнөө удирдах чадварыг сайжруулж, хөдөлгөөнийг хөгжүүлэх ач холбогдолтой.

Та сард “Эх хүүхдийн хөгжлийн хөгөлбөр”-г оролцсон тухай сэтгэгдлээ хуваалцана уу.



Four horizontal dotted lines for writing a response.

Та хүүхдээ өстөж бойжуулахад тулгамдаж байгаа асуудал болон шөвлөгөө авахыг хүсэж буй зүйлээ чөлөөтэй тэмдэглээрэй.

Four horizontal dotted lines for writing a response.



Хөгөлбөрийн үйл ажиллагаанд оролцож буй байдал ба хүүхдийн хөгжлийн ахицын талаарх багшийн тэмдэглэл.

Handwriting practice area with four rows of dotted lines. Each row contains two different colorful icons: a clownfish, a bicycle, a ball, and a triangle with dots. The icons are arranged in a grid pattern across the rows.

Бөмбөгөөр тоглох



Бага насны ямар ч хүүхдийн хувьд сонирхолтой тоглоом болох тод, олон өнгийн бөмбөгүүдийг өмнө нь дэлгэж чөлөөтэй авч тоглох боломжийг олгоно. Бөмбөгийг шидэж, өнхрүүлэн зугаацаж тоглох нь шинэ орчинд дасгахын зэрэгцээ бөмбөг дамжуулж харилцан тоглох нь хүүхдийн харилцааны суурь чадварыг хөгжүүлдэг. Бөмбөг бөөрөнхий хэлбэртэй учир атгахад амаргүй ба уг үйлдлээр аливаа зүйлийг атгах, барих, шидэх зэрэг нарийн хөдөлгөөн, гар хөлийн бүлчлэнгийн үйл ажиллагааг сайжруулахад тустай. Тоглож дуусаад бөмбөгөө хурваснаар хэрэглэсэн зүйлээ эмхэлж, цэгцлэх гэсэн өдөр тутмын дадал хэвшилд сургах зорилготой.

Та сард "Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр"-г оролцсон тухай сэтгэгдлээ хуваалцана уу.



.....

.....

.....

Та хүүхдээ өсгөж бойжуулахад тулгамдаж байгаа асуудал болон зөвлөгөө авахыг хүсэж буй зүйлээ тухай бүрт нь тэмдэглээрэй.




.....

.....

.....

Хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцож буй байдал ба хүүхдийн хөгжлийн ахицын талаарх багшийн тэмдэглэл.

Хөдөлгөөнт дүү



Бага насны хүүхэд ярьж чадахгүй ч, томчуудын дуулахыг сонсох, эсвэл хамт дууны аянд найгах, энгэргээ нааж гэрэх зэрэгт дургтай байдаг. Хүүхэдтэйгээ хамтдаа дууны аянд тааруулан алга ташин найгаж, гараа хөдөлгөж дуулан тоглосноор хүүхдийн сонстол, хараа болон хүргэх мэдрэхүй, мөн хариу үйлдэл үзүүлэх тархи, бие эрхтний хөдөлгөөнийг хөгжүүлдэг. Түүнчлэн хүүхдийн хувьд хамгийн дотны хүн болох ээж нь хүүхдээ энгэргээ гэрэрч, магтаж эрхлүүлэх нь хүүхдийн харилцааны чадвар болон хэл ярианы суурь чадварыг ч сайжруулах ач холбогдолтой.


Та сард “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-г оролцсон санал сэтгэгдлээ хуваалцана уу.



Та хүүхдээ өсгөж бойжуулахад тулгамдаж байгаа асуудал болон зөвлөгөө авахыг хүсэж буй зүйлээ тухай бүрт нь тэмдэглээрэй.



Хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцож буй байдал ба хүүхдийн хөгжлийн ахицын талаарх багшийн тэмдэглэл.



Цаасаар тоглох



Хүүхэд хэрэггүй, хуучин сонингийн цаасыг гар, хурууны булчингийн тусламжтайгаар урж

жижиглэн тоглох ба тоглож дууссаны дараа чимхэх,





базаж авах зэргээр ууганд хурааж хийнэ.

Цаасыг чимхэх, базаж, урж таслах, сэгсрэх зэргээр зугаацан тоглох нь хүүхдийн гар хурууны нарийн чимхлүүр хөдөлгөөнийг хөгжүүлдэг. Мөн цаасыг барьж хөдөлгөхөд гарах дуу чимээг сонсох, хэлбэр болон хөдөлгөөн нь хэрхэн өөрчлөгдөж буйг харах, улмаар шүргэх, атгаж авах зэргээр хүртэх болон бусад мэдрэхүйг нь нэвчрөөж, сэдгээх зорилготой.

Та сард “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-т оролцсон тухай сэтгэгдлээ хуваалцана уу.

Та хүүхдээ өстгөж бойжуулахад тулгамдаж байгаа асуудал болон зөвлөгөө авахыг хүсэж буй зүйлээ тухай бүрт нь тэмдэглээрэй.

Хөтөлбөрийн үйл ажиллагаанд орошож буй байдал ба хүүхдийн хөгжлийн ахицын талаарх багшийн тэмдэглэл.



Хөдөлгөөнт тоглоом



Энэ насны хүүхдүүдийн эзэмших шаардлагатай алхах, бие даан явах чадварыг хөгжүүлэхийн тулд янз бүрээр алхах үйлдлийг тойрог байдлаар дараатай, ээлж















тодорхой давтамжтайгаар хийж тоглоно. Хүүхэд хонгилоор мөлхөж гараад, нарийн шулуун замаар тэнцвэрээ олж алхан, саадтай замыг давж явна. Уг тоглоомоор хүүхдийг тухайн үйлдлүүдийг бага багаар дэс дараатай, тойргоос хазайж гаралгүйгээр өөрийн ээлжийг тэвчээртэй хүлээж хийж чаддаг болгохыг зорих ба ийнхүү бүх биеэрээ хөдлөх нь тэдний хэл яриа болон сэтгэл зүйн хөгжилд чухал үүрэгтэй юм.

Та сард “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-г оролцсон тухай сэтгэгдээ хуваалцана уу.

Та хүүхдээ өстөж бойжуулахад тулгамдаж байгаа асуудал болон өвлөгөө авахыг хүсэж буй зүйлээ тухай бүрт нь тэмдэглээрэй.



Хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцож буй байдал ба хүүхдийн хөгжлийн ахицын талаарх багшийн тэмдэглэл.

Харишаж тоглох



Энэ нь эх хүүхдийн хоорондын итгэлцэл, эрхэлж наалдах харилцаанд суурилсан бие биедээ хүрэлцэж, харилцан тоглох үйл ажиллагаа юм. Ээж нь суугаагаараа хүүхдээ өвөр дээрээ зогсоон, үндсэн багшийн хэлэх ҮГ, үзүүлэх хөдөлгөөнийг дуурайж “цэнэг томоос том ургалаа”, “цэнэг сажинд ганхан найгалаа” гэх зэргээр хүүхэдтэйгээ хамтдаа найган хөдөлж тоглоно. Энэ тоглоомын үед хүүхдийн олон мэдрэхүйг цогцоох, тэнцвэрээ хадгалах зэрэг харилцан үйлдэл үзүүлэх чадварыг нь хөгжүүлнэ. Ээж хүүхэдтэйгээ бүх биеэрээ харишаж, эх үрийн харилцаа улам дотносон ойртоно.

Та сард “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-г оролцсон санал сэтгэгдлээ хуваалцана уу.








Та хүүхдээ өстөж бойжуулахад тулгамдаж байгаа асуудал болон зөвлөгөө авахыг хүсэж буй зүйлээ тухай бүрт нь тэмдэглээрэй.





Хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцож буй байдал ба хүүхдийн хөгжлийн ахицын талаарх багшийн гэмдэглэл.






“Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр” нь бага балчир хүүхдийг тоглоомын аргаар хөгжүүлэх, тэдний эцэг эх, асран хамгаалагчдад дэмжлэг, зөвлөгөө өгөх зорилготой үйл ажиллагаа юм.

Үе тэнгийн олон хүүхдүүд хамтдаа зугаацан тоглох, асран хамгаалагчид бусад эцэг эхчүүдтэй нээлттэй ярилцаж, хүүхэд өсгөж бойжуулах талаар туршилага хуваалцан, мэдээлэл солилцож, баги болон бусад холбогдох мэргэжилтнээс зөвлөгөө авах боломжтой хөтөлбөр юм.

Бид энэхүү хөтөлбөрөөр дамжуулан эцэг эх, асран хамгаалагч та бүхэнд гэр орондоо үр хүүхдээ тогтмол хөгжүүлэх чадварыг дээшлүүлэх нэгэн зорилгоор тусалж дэмжин, чин сэтгэлээсээ ажиллаж байна.

Хөтөлбөртөө тогтмол ирсэнд баярлалъя.



ХАВСРАЛТ 2

Хүүхдийн мэдээлэл болон сар бүрийн
тэмдэглэл (Маягт, жишээ)

ЭХ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОГЧ ХҮҮХДИЙН МЭДЭЭЛЭЛ

Овог, нэр			зураг	
Хүйс	Эр / Эм	(Дугуйлна уу)		
Төрсөн огноо				
Асран хамгаалагчийн овог, нэр				
Утас				
Ам бүл	<input type="checkbox"/>			
(Овог нэр, хүүхдийн хэн нь болохыг бичнэ)	<input type="checkbox"/>			
	<input type="checkbox"/>			
	<input type="checkbox"/>			
	<input type="checkbox"/>			
*Хамт амьдарч байгаа бол өмнөх нүдийг тэмдэглэнэ үү.	<input type="checkbox"/>			
Гэрийн хаяг				
Амьдралын нөхцөл байдал	<input type="checkbox"/> Орон сууцны хороололд	<input type="checkbox"/> Гэр хороолол:		
	<input type="checkbox"/> Амины сууц	<input type="checkbox"/> Байшин		
	<input type="checkbox"/> Орон сууц	<input type="checkbox"/> Гэр		
	<input type="checkbox"/> Түрээсийн байр	<input type="checkbox"/> Түрээсийн		
	<input type="checkbox"/> Нийтийн байр	<input type="checkbox"/> хашаа	<input type="checkbox"/> байшин	
	<input type="checkbox"/> Бусад /...../	<input type="checkbox"/> гэр		
		<input type="checkbox"/> Бусад /...../		

ЭХХХ–т илгээсэн байгууллага	<input type="checkbox"/> 18 сартай хүүхдийн үзлэг	Үзлэгт хамрагдсан огноо:		
		Онош / үнэлгээ: Эмчийн зөвлөмж		
	<input type="checkbox"/> Өрх сумын ЭМТ, эмч	Онош / үнэлгээ: Эмчийн зөвлөмж		
	<input type="checkbox"/> ХБХЭМБНХ- ын Салбар комисс	Хурлаар орсон огноо:		
		Комиссын шийдвэр:		
		Онош:		
		Хөгжлийн бэрхшээлийн төрөл:		
	Чадвар алдалт:			
	Нийгмийн халамжийн тэтгэмж авдаг эсэх			
	<input type="checkbox"/> Тийм /...../			
/			
	<input type="checkbox"/> Үгүй			
	Өөрөө	Тайлбар:		
	Бусад	Тайлбар:		
Эрүүл мэндийн байдал	Хавсарсан эмгэгтэй эсэх			
	<input type="checkbox"/> Тийм/...../			
	<input type="checkbox"/> Үгүй			
	Эмийн эмчилгээ			
	<input type="checkbox"/> Тийм/...../			
	<input type="checkbox"/> Үгүй			
Тусламж үйлчилгээ авдаг байгууллага	Эмнэлэг, сэргээн засах	Нийгмийн хамгаалал	Боловсрол	Бусад
Асран хамгаалагчийн хөтөлбөрөөс хүсэн хүлээж буй үр дүн				
Тэмдэглэл				

САР БҮРИЙН ТЭМДЭГЛЭЛ

Овог нэр: _____

Эцэг эх, асран хамгаалагчдын хүсэл

--

..... удаасарөдөр Хаана:

Үйл ажиллагаанд оролцсон байдал	
Хамгийн их сонирхож, идэвхтэй оролцсон үйл ажиллагаа	
Өмнөх сарын хөтөлбөрөөс хойшхи ахиц, өөрчлөлт	
Асран хамгаалагчаас сонссон мэдээлэл болон тэдний үйл ажиллагаанд оролцсон байдал байдал	
Багшийн өгсөн Зөвлөгөө	
Үзүүлэх дэмжлэгийн чиглэл	

ЭХ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОГЧ ХҮҮХДИЙН МЭДЭЭЛЭЛ (ЖИШЭЭ)

Овог нэр	Б овогтой Х	
Хүйс	Эр / Эм	(Дугуйлна уу)
Төрсөн огноо	2016.05.04	
Асран хамгаалагчийн овог нэр	Ээж Д	
Утас	88XXXXXX	
Ам бүл (Овог нэр, хэн нь болох) *Хамт амьдарч байгаа бол өмнөх нүдийг тэмдэглэнэ үү.	<input checked="" type="checkbox"/> аав Б	
	<input checked="" type="checkbox"/> ээж Д	
	<input checked="" type="checkbox"/> ах С	
	<input checked="" type="checkbox"/> эгч Н	
	Ам бүл-5 хүүхдийн тоо-3	
Гэрийн хаяг	Хөвсгөл, мөрөн сум, Х-р баг, ХХ-ХХ	
Амьдралын нөхцөл байдал	<input type="checkbox"/> Орон сууцны хороололд	<input checked="" type="checkbox"/> Гэр хороолол:
	<input type="checkbox"/> Амины сууц <input type="checkbox"/> Орон сууц <input type="checkbox"/> Түрээсийн байр <input type="checkbox"/> Нийтийн байр <input type="checkbox"/> Бусад /.....//	<input checked="" type="checkbox"/> Байшин <input type="checkbox"/> Гэр <input type="checkbox"/> Түрээсийн <input type="checkbox"/> Хашаа <input type="checkbox"/> Байшин <input type="checkbox"/> Гэр <input type="checkbox"/> Бусад /.....//
ЭХХХ–т илгээсэн байгууллага	<input checked="" type="checkbox"/> 18 сартай хүүхдийн үзлэг	Үзлэгт хамрагдсан огноо: 2017 оны 11 сарын 24 (18 сар 20 хоног) Онош / үнэлгээ: Дауны хам шинж Эмчийн зөвлөмж: – Өдөрт 3-4 удаа хооллох – 1-2 удаа хөнгөн зууш өгөх – Өөрөөр нь шүдийг нь угаалгах – Аяганаас уулгаж сургах – Ганцаараа явахыг нь дэмжих – ЭХЭМҮТ-ийн мэдрэл, нүдний эмчид үзүүлэх – Хөдөлгөөн, ахуй засал хийлгэх
	<input type="checkbox"/> Өрх сумын ЭМТ, эмч	Онош / үнэлгээ: Эмчийн зөвлөмж:

ХАВСРАЛТ 2

ЭХХХ–т илгээсэн байгууллага	<input type="checkbox"/> ХБХЭМБНХ-ын Салбар комисс	Хурлаар орсон огноо:		
		Комиссын шийдвэр:		
		Онош: Хөгжлийн бэрхшээлийн төрөл: Чадвар алдалт:		
		Нийгмийн халамжийн тэтгэмж авдаг эсэх <input type="checkbox"/> Тийм /.....// <input type="checkbox"/> Үгүй		
<input type="checkbox"/> Өөрөө	Тайлбар:			
<input type="checkbox"/> Бусад	Тайлбар:			
Эрүүл мэндийн байдал	Хавсарсан эмгэгтэй эсэх <input type="checkbox"/> Тийм/...../ <input checked="" type="checkbox"/> Үгүй			
	Эмийн эмчилгээ <input type="checkbox"/> Байгаа/...../ <input checked="" type="checkbox"/> Байхгүй			
Тусламж үйлчилгээ авдаг байгууллага	Эмнэлэг, сэргээн засах	Нийгмийн хамгаалал	Боловсрол	Бусад
	ӨЭМТ болон Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн эмчийн хяналтад байдаг.	Халамжийн тэтгэмж авдаг.	Гэртээ байдаг.	
Асран хамгаалагчийн хөтөлбөрөөс хүсэн хүлээж буй үр дүн	Хүүхдээ нийгэмшүүлж, хэл яриаг нь хөгжүүлмээр байна. Мөн ийм бэрхшээлтэй хүүхдүүд хэрхэн боловсрол эзэмшиж, хөгжих, нийгэмд бие даан амьдрах боломжтой байдаг талаар мэдээлэлтэй болмоор байна. Цаашдаа тухайн насандаа бусад хүүхдүүдийн адил цэцэрлэг сургуульд яваасай гэж хүсч байна.			
Тэмдэглэл	Дутуу 1800 гр жинтэй төрсөн. Зүрхний цоорхойтой архаг бронхиттой амархан ханиад хүрдэг. Ханиад нь хүндрэхдээ амархан.			

САР БҮРИЙН ТЭМДЭГЛЭЛ (ЖИШЭЭ)

Эцэг эх, асран хамгаалагчдын хүсэл

Бусад хүүхдийн дунд орж өөрийгөө бусдад ойлгуулах, ярьдаг болгох, хөлөөрөө явдаг болох.

1 дэх удаа 2018 оны 4-р сар 4 өдөр Хаана: ЭМГ

Үйл ажиллагаанд оролцсон байдал	Ээж эгчтэйгээ хамт ирсэн. Бөмбөг тоглоход бусдын дунд орж тоглож эхэлсэн. Бусдаас бишүүрхэх байдал багассан. Нэрээр нь дуудахад харна. Шулуун замаар явахдаа хэвтэж дүргүйцлээ илэрхийлж байсан. Тоглоомон хонгил дундуур оруулахад дургүйцсэн. Сонин урахад гарын булчин сул байсан. Аливаа үйл ажиллагаанд эгчийнхээ тусламжтай оролцсон.
Хамгийн их сонирхож, идэвхтэй оролцсон үйл ажиллагаа	Усан сан дотор орж суулган дээрээс нь сонингийн цаасыг бороо орж буй мэтээр асгахад баярлаж байсан ба усан сангаас гаргах гэхэд дургүйцсэн. Шүхэр хөөрлөө буулаа гэхэд хөөрч баярлаж инээж байсан.
Өмнөх сарын хөтөлбөрөөс хойшхи ахиц, өөрчлөлт	
Асран хамгаалагчаас сонссон мэдээлэл болон үйл ажиллагаанд оролцсон байдал	Эгчтэйгээ их тоглодог. Би хүүхэдтэй ажиллах цаг багатай байдаг. Энэхүү хөтөлбөрт бид бүгдийг оролцуулсанд их баяртай байна. Энэ хөтөлбөрт явснаараа миний хүүхэд өөрчлөгдөж, хөгжилд нь ахиц гарна гэж бодож байна. Гэрт эдгээр үйлдлүүдийг хийлгээд байя гэж бодож байна.
Зөвлөгөө	Хөтөлбөр 6 удаа явагдах тул таслалгүй хамрагдах хэрэгтэй. Хөтөлбөрийн тоглоомуудыг дарааллын дагуу хийлгэж байх, энэ сардаа зөвхөн сонин уруулж сургах. Дууг аль болох олон сонсгож, үргэлж хамт тоглодог эгчээр нь заалгаж, хамтдаа тоглон дараагийн сарын хөтөлбөртөө дуу, тоглоомын талаар ойлголттой болоод ирэхийг зөвлөв. Хүүхдийн доод мөчний булчин сул байгаа тул аль болох зогсоох, дуртай зүйлийг өндөрт тавьж өөрөөр нь тэмүүлж авахуулах зэрэг үйлдлүүдийг хийлгэх.
Үзүүлэх дэмжлэгийн чиглэл	Нэгдсэн эмнэлгийн сэргээн засалтын эмч дээр эсвэл ойрхон рашаан сувилалд явуулах. Энгийн цэцэрлэгт хамруулах талаар ярилцах.


2 дахь удаа 2018 оны 5-р сар 8 өдөр Хаана: ЭМГ

Үйл ажиллагаанд оролцсон байдал	Ээж эгчтэйгээ хамт ирсэн. Эхэндээ бага зэрэг ээжийнхээ өвөр дээр байж байгаад бусад хүүхдүүдийн дунд орж бөгсөөрөө нааш цааш хөдлөн бөмбөгөөр харилцан тоглосон. Багшийн хэлснээр бөмбөгөө хайрцагт сайн хийж байсан. Дууны аянд бөгсөн дээрээ хөдлөн баярласан. Тоглоом, үйл ажиллагаанд оролцохдоо эгчийгээ харж дагаж хийж байсан. Нэрээр нь дуудахад эргэж хардаг. Шулуун зам, тоглоомон хонгилоор цээжээрээ гулсах, бөгсөөрөө хөдлөх зэргээр явсан.
Хамгийн их сонирхож, идэвхтэй оролцсон үйл ажиллагаа	Бөмбөг хураах, цэцэг наах үйлдлийг сайн гүйцэтгэсэн. Сонингийн цаас урах үйлдлийг өмнөхөөсөө сайн гүйцэтгэсэн.
Өмнөх сарын хөтөлбөрөөс хойшхи ахиц, өөрчлөлт	Дууны хэмнэлээр багшийн хөдөлгөөнийг харж дуурайн хийхийг оролдон, бөгсөн дээрээ бүжиглэх хөдөлгөөн хийж байсан.
Асран хамгаалагчаас сонссон мэдээлэл болон үйл ажиллагаанд оролцсон байдал	Эгч нь гэртээ дуу сонсгож, сонин уруулах үйлдлийг сайн хийлгэсэн. Ахиц гарч байгаа гэж бодож байгаа. Энэ хөтөлбөртөө таслалгүй явна.
Зөвлөгөө	Хөтөлбөртөө идэвхтэй оролцож, гэртээ хүүхдэдтэйгээ сайн харилцаж, зааж сургаж байгаад талархаж байгаагаа хэлсэн. Сэргээн засах эмчилгээнд явж доод булчингийн хөгжил сайжруулах, хүүхэдтэй сайн ярихыг зөвлөсөн.
Үзүүлэх дэмжлэгийн чиглэл	Өөрөөр нь хоол идүүлж сургах, бие даах чадварыг нь дэмжиж байгаад энгийн цэцэрлэгт хамруулах.



“Мөнхийн Үсэг” ХХК-д хэвлэв.
Утас: 319658, 70140459
Вэб хаяг: www.munkhiin-useg.mn

ISBN 9919-9519-3-5



9 789919 951931